



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 80

Номгон

Ашиглалтын гэрээ байгуулж,  
ажиллах тухай

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XVI хуралдааны 16/05 дугаар тогтоолоор Супрессор өрхийн эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2005 онд ашиглалтад орсон 2018 оны дахин үнэлгээгээр 27 624 272,87 төгрөгөөр үнэлэгдсэн өрхийн эмнэлгийн барилгын худалдах доод үнийг 25,0 сая төгрөгөөр тогтоож дуудлагын худалдаагаар худалдах шийдвэр гарсан. Уг барилгын дуудлагын худалдааг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй, цаашид өрхийн эмнэлгийн барилгын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 43 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-ийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

1.1. Баянхонгор сумын Супрессор өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтарч хэрэгжүүлэх “Утаагүй-Баянхонгор” төслийг ард иргэдэд сургалт сурталчилгаа хийх Инновацийн загвар төв байгуулж ашиглалтын гэрээгээр ашиглуулах;

1.2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XVI хуралдааны 16/05 дугаар тогтоолоор барилгыг дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэснийг өөрчилж дараагийн хурлын хуралдаанд тогтоолын төсөл өргөн барих;

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР